

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ**

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН
МАГАДЛАЛЫН ДҮГНЭЛТИЙН НЭГТГЭЛ**

2024 оны 03 дугаар сарын 20

Дугаар 0319.2024

Улаанбаатар хот

Барилга, байгууламжийн байршил:	Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хороо			
Барилга, байгууламжийн нэр, зориулалт:	850 хүний суудалтай хүүхэд, залуучуудын театрын барилгын хаяг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахилгаан шатны ажлын зураг төсөл, төсөв			
Зургийн шифр:	B'S-210/19-08(A)			
Хүчин чадал:	Цахилгаан шат: 250кг даацтай, 1 хүний багтаамжтай, 3 зогсолттой, Хаяг: 49.0 м ²			
Захиалагч:	Соёлын яам			
Санхүүжилтийн үүсвэр: эх	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар			
Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр:	"Балданс" ХХК			
Регистрийн дугаар:	2671506			
Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:	2028.08.13			
Ажлын төрөл:	1.2.2, 1.5.1 заалтын дагуу			
Зургийн баталсан тушаалтан, дугаар, огноо: даалгавар, албан	Соёлын яамны төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр баталсан 01/2024 дугаартай Хүүхэд залуучуудын театрын барилгад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн лифт төлөвлөх, хаягжилтын зураг төсөл боловсруулах ажлын даалгавар			
Барилга, байгууламжийн зураг төслийн бүрдэл:				
Зураг төслийн бүрдэл:	Зураг төсөл		Магадлал хийсэн экспертний нэр	
	Гүйцэтгэсэн байгууллага:	Шалгасан архитектор, инженер		
Барилга архитектур:	"Балданс" ХХК	Б.Онон	Д.Пүрэв	
Барилгын төсөв:	"Скайлайн дизайн" ХХК	Ч.Давааням	Г.Пэлээсүрэн	
Зураг төсөлд магадлал хийсэн экспертүүдээс зөвшөөрсөн 2, татгалзсан эксперт байхгүй байна.				
Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй 850 хүний суудалтай хүүхэд, залуучуудын театрын барилгын хаяг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахилгаан шатны ажлын төсвийн задаргаа				
№	Барилгын үндсэн хийц	Төсөвт өртөг /төг/	Ажлын тоо хэмжээ	Нэгж өртөг /төг/
1	Барилга угсралтын ажил:			
1.1	Цахилгаан шатны угсралтын ажил	12,504,825	1	12,504,825

1.2	Хаяг /м ² /: Нерж төмрөөр уйгаржин болон кирил бичгээр хаяг хийх, хаягийг цэнхэр акрилк хавтангаар бүрэх, гэрэлтүүлэг хийж угсарч байрлуулах	31,679,177	49	653,179
Хэсгийн дүн:		44,184,002		
2	Тоног төхөөрөмж:			
ТТ	Цахилгаан шат, даац 250кг, багтаамж 1 хүн, 3 зогсолттой	89,146,348	1	89,146,348
Хэсгийн дүн:		89,146,348		
Төсөвт өртгийн нэгдсэн товчоо				
1	Хаяг:			31,679,177
2	Цахилгаан шат:			101,651,173
НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:				133,330,350

Тайлбар: Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй "850 хүний суудалтай хүүхэд, залуучуудын театрын барилга"-ын ажлын зураг төсөл нь 2020 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн ЕД-1276/2020 дугаартай магадлалын нэгтгэсэн дүгнэлтээр албажсан.

Тухайн ажлын захиалагч, захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллага, зураг төсөл зохиогчийн хамтарсан 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн хурлын шийдвэр, Соёлын яамны төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр баталсан 01/2024 дугаартай Хүүхэд залуучуудын театрын барилгад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн лифт төлөвлөх, хаягжилтын зураг төсөл боловсруулах ажлын даалгаварыг үндэслэн нэмэлт ажлын зураг төслийг боловсруулсан байна.

Соёлын яамнаас 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 3/3050 дугаартай албан бичиг, "Балданс" ХХК-аас 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн АБ-014/24 дугаартай албан бичгээр нэмэлт ажлын зураг төсөлд магадлал хийлгэх хүсэлтийг ирүүлсэн.

Төсөв: Эксперт нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй "850 хүний суудалтай хүүхэд, залуучуудын театрын барилга"-ын хаяг хийх ажлын төсөвт өртгийг **31,679,177.0** (гучин нэгэн сая зургаан зуун далан есөн мянга нэг зуун далан долоон) төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахилгаан шатны ажлын төсөвт өртгийг **101,651,173.0** (нэг зуун нэг сая зургаан зуун тавин нэгэн мянга нэг зуун далан гурван) төгрөгөөр тус тус хянасан байна.

"Барилгын тухай" Монгол улсын хуулийн /шинэчилсэн найруулга 2016 он/ 38.1.2-т "барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсгийг боловсруулсан зохиогч тухайн зураг төслийг баталгаажуулан, мэргэжлийн хариуцлага хүлээх", 38.1.3-т "зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх", 39.4-т "Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээнэ.", 39.5-д "Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаарх дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ".

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй "850 хүний суудалтай хүүхэд, залуучуудын театрын барилга"-ын хаяг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахилгаан шатны ажлын зураг төсөл, төсөвт "Барилгын тухай хууль"-ийн 25.5, 34.1.4, 34.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тухай" 51 дүгээр тогтоол, 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийг тус тус үндэслэн магадлал хийх ажлыг зохион байгуулж, нэгтгэн бүртгэлийн дугаар олгов.

Дүгнэлтийн нэгтгэл нь экспертүүдийн 3 хуудас магадлалын дүгнэлтийн хамт хүчинтэй.

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД МАГАДЛАЛ
ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН:**

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ



Ц.АМАРСАНАА

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Д.АЛТАНХУЯГ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН
ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Э.ХАНГАЛ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН
ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

Г.МӨНХБОЛД

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН
ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.САРАНТУЯА